



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/118/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ө.Сийлэгмаа

Утас: 7000-3775

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
НЭМ	Нийгмийн эрүүл мэндийн төв



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	Error! Bookmark not defined.
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Error! Bookmark not defined.
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.



Аудитын гэрчилгээ

ЧОЙБАЛСАН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА. Б. НЯМДОРЖ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга У.Уртнасан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 18-нээс 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 ны 02 дугаар сарын 27 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай үзүүлэх, салбар хоорондын уялдааг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих замаар сумын загвар эмнэлгийн хөгжлийг хангах” гэж тодорхойлсон байна.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилт 1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, салбар дундын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог сайжруулна.

Зорилт 2: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3: Хүний нөөцийн бодлогыг эрэлтэд нийцүүлэн тогтвортой хөгжүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа, хандлагыг төлөвшүүлэх үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангана.

Зорилт 4: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, орон нутгийн хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлнэ.

Зорилт 5: Эрүүл мэндийн технологийн дэвшлийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэн байгууллагын хөгжил, ээлтэй байдлыг бүрдүүлнэ.

Зорилт 6: Эм зүйн тусламж үйлчилгээний хүртээмжтэй тогтвортой байдлыг ханган, зайлшгүй шаардлагатай, баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Axploger программ хангамж ашигладаг байна.

Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.



2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 30 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 20019 оны жилийн эцсийн тайланг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 347,059.3 мянган төгрөгөөс тооцон 6,941.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,941.2 мянган төгрөгөөр тооцсон төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн чухал үзүүлэлт болох зардлаас мтериаллаг байдлын түвшинг тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,345.5 мянган төгрөгөөр буюу 10,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	-
Авлага	4,095.70	4,095.70	-
Урьдчилгаа	0	0	-
Бараа материал	45,001.80	54,893.20	9,891.40
Үндсэн хөрөнгө	569,094.00	648,051.60	78,957.60
Хуримтлагдсан элэгдэл	-56,090.00	-84,593.50	-28,503.50
Нийт хөрөнгө	562,101.50	622,447.00	60,345.50
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	561,750.80	622,447.00	60,696,2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	562,101.50	622,447.00	60,345.50

Авлага дансанд өссөн буурсан үзүүлэлт байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 5051,4 мянган төрөгийн үнэ төлбөргүй эм хүлээн авсан, урсгал төсвөөс 4840,0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 78,957.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд хөрөнгө оруулалт хийснээс шалтгаалжээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 51,673.5 мянган төгрөгөөр ариун цэврийн байгууламж, Аймгийн Орон Нутгийн Хөгжлийн Сангийн хөрөнгөөр 14,794.0 эмнэлэгийн тоног төхөөрөмж, 6,990.0 тавилга, Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5,500.0 гэрэлтүүлэг, зуухны засварын хөрөнгө оруулалтын дүнгээр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 622,447.0 мянган төгрөг болж 60,345.5 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 350,511.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тусгай зориулалтын шилжүүлгээр 312,172.5, нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 27,554.5, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 10,784.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 312,816.1 мянган төгрөг буюу 89,3 хувьтай байна. Төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 16,392.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас ахмадын болон хүүхдийн сувилалын зардалд 1,300.0 мянган төгрөг, сорьц тээврийн зардал 35.8,4 мянган төгрөг, урьдчилан сэргийлэх төлбөртэй үзлэг хийсэн орлого 450,0 мянган төгрөг, актлагдсан хөрөнгө сэлбэгээр худалдсанаас орсон орлого 500,0 төгрөгийн нэмэлт төсөв бүрдүүлсэн байна.

Үүнээс: Сорьц тээврийн зардалд 38,4, сэлбэг, шатахууны зардалд 977,1, сувилалын хоолны зардалд 1300,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 30 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 30 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.



Аудитаар нийт 72,688.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5,051.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 383,9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 59,351.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 7,901.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 67,636.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Цалингаас түүвэр хийн дахин тооцоолол хийж үзэхэд 2 хүнд 283,9 мянган төгрөгийн илүү цалин олгосон, дотоод журмын дагуу 1 хүнд ажлаас халагдсаны тэтгэмж 100,0 төгрөгийг 2 дахин олгосон байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

2. Ерөнхий журналын бичилтүүдийг бүхэлд нь шалгаж үзэхэд 44 гүйлгээ буюу 7,439.2 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардлын дансанд бичсэн байгаа нь үнэлгээ ба хуваарилалт, гэсэн батламж мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3, 13.4, 13.5, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

3. Тайлант хугацаанд 106,926.3 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан боловч эдгээрээс 47,575.2 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ нь Е-баримттай байна. 59351,1 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 462,5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Чойбалсан сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 157 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хоцроосон байна. .

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3600,0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэнийг хэрэгжүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээ нөхсөн, ашиглагдахгүй байгаа 462.5 мянган төгрөгийн хэрэглээний программ хангамжийг данс бүртгэлээс хасаагүй байна.
- 1.2. **Эрсдэл:** Хөрөнгийн ашиглалтын үр өгөөж буурах.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, УСНББОУС 17-ын дагуу ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

			СТ-1А
4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49,097,556.79	58,988,904.03
33	АВЛАГА	4,095,746.69	4,095,746.69
335	Бусад авлага	4,095,746.69	4,095,746.69
3351	Байгууллагаас авах авлага	3,486,277.69	3,486,277.69
3352	Хувь хүмүүсээс авах авлага	609,469.00	609,469.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,001,810.10	54,893,157.34
351	Түүхий эд материал	2,177,580.84	6,309,089.28
35130	Эм боох материал	2,177,580.84	6,309,089.28
354	Хангамжийн материал	42,824,229.26	48,584,068.06
35410	Бичиг хэргийн материал	2,098,695.00	1,453,920.00
35420	Аж ахуйн материал	40,347,065.06	46,943,248.06
35430	Сэлбэг хэрэгсэл	11,000.00	11,000.00
35460	Хүнсний материал	367,469.20	175,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	513,003,983.03	563,458,104.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	513,003,983.03	563,458,104.65
392	Биет хөрөнгө	486,031,983.03	536,486,104.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	404,227,177.61	458,900,721.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(13,151,826.77)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,767,203.20	35,767,203.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,377,883.77)	(17,633,956.13)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,054,491.01	58,848,491.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,602,918.37)	(27,406,466.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,403,167.00	22,393,167.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,398,228.51)	(12,382,453.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,007,442.00	44,507,442.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,048,467.14)	(13,356,216.86)
393	Биет бус хөрөнгө	26,972,000.00	26,972,000.00
39301	Програм хангамж	662,540.00	662,540.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(662,540.00)	(662,540.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	26,972,000.00	26,972,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	562,101,539.82	622,447,008.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	561,750,881.22	622,447,008.68
51	Засгийн газрын хувь оролцоо	561,750,881.22	622,447,008.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	124,683,931.36	124,683,931.36
51101	Өмч: - төрийн	124,683,931.36	124,683,931.36
512	Хуримтлагдсан үр дүн	108,264,530.63	168,960,658.09
51210	Өмнөх үеийн үр дүн	109,274,567.80	108,264,530.63
51220	Тайлант үеийн үр дүн	(1,010,037.17)	60,696,127.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	328,802,419.23	328,802,419.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	562,101,539.82	622,447,008.68

				СТ-2А
4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН				
				/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	269,793,500.00	407,755,459.62	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	77,249,999.62	
120	Нийтлэг татварын бус орлого	-	77,249,999.62	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	77,249,999.62	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	950,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		76,299,999.62	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	269,793,500.00	330,505,460.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	264,772,500.00	322,957,200.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	264,772,500.00	322,957,200.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,021,000.00	1,327,100.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,021,000.00	1,327,100.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	6,221,160.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	6,221,160.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	270,803,537.17	347,059,332.16	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	270,803,537.17	347,059,332.16	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	268,309,626.17	329,467,108.16	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,562,600.00	181,397,049.00	
210101	Үндсэн цалин	147,609,567.00	118,821,198.00	
210102	Нэмэгдэл	84,206.00	40,793,500.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,798,000.00	
210104	Урамшуулал	11,868,827.00	17,984,351.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,289,904.00	22,971,180.00	
210201	Тэтгэврийн даатгал	13,016,028.00	16,039,864.00	
210202	Тэтгэмжийн даатгал	1,577,386.00	1,811,183.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,339,618.00	1,448,945.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	309,777.00	333,743.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,047,095.00	3,337,445.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,298,263.01	8,606,559.00	
210301	Гэрэл, цахилгаан	3,017,548.00	3,757,409.00	
210302	Түлш, халаалт	4,280,715.01	4,811,650.00	
210303	Цэвэр, бохир ус	-	37,500.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	14,097,943.60	22,426,765.40	
210401	Бичиг хэрэг	726,279.00	3,701,105.00	
210402	Тээвэр, шатахуун	11,297,405.60	12,275,784.40	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,457,600.00	1,474,900.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	211,520.00	1,666,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	405,139.00	3,308,976.00	
2105	Нормативт зардал	24,210,792.80	34,855,686.38	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,832,624.00	25,826,093.18	
210502	Хоол, хүнс	5,243,275.80	7,224,193.20	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	134,893.00	1,805,400.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,436,390.00	4,929,140.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,426,800.00	
210604	Урсгал засвар	2,436,390.00	3,502,340.00	
2107	Томилолт, зочны зардал	1,094,000.00	723,200.00	
210702	Дотоод албан томилолт	1,094,000.00	723,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,102,904.00	18,541,786.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,550,260.00	17,382,560.00	



210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	228,250.00	235,090.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,950.00	42,136.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	50,000.00
210807	Газрын төлбөр	51,444.00	52,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	180,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,216,828.76	35,015,742.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,399,520.00	6,512,320.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,817,308.76	28,503,422.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,493,911.00	17,592,224.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,000.00	1,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	120,000.00	1,200,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,373,911.00	16,392,224.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,373,911.00	16,392,224.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,010,037.17)	60,696,127.46
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,010,037.17)	60,696,127.46

			СТ-2А
4.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН			
			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	270,213,500.0	331,455,460.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	950,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	950,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	950,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	950,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	270,213,500.0	330,505,460.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	264,772,500.0	322,957,200.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	264,772,500.0	322,957,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,021,000.0	1,327,100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,021,000.0	1,327,100.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	420,000.0	6,221,160.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	6,221,160.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	270,213,500.0	331,455,460.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	270,213,500.0	331,455,460.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	267,719,589.0	313,863,236.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,813,606.0	181,397,048.0
210101	Үндсэн цалин	147,710,200.0	118,821,197.0
210102	Нэмэгдэл	-	40,793,500.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,798,000.0
210104	Урамшуулал	12,103,406.0	17,984,351.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,963,755.0	23,046,324.0
210201	Тэтгэврийн даатгал	12,917,707.0	16,115,008.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,235,100.0	1,811,183.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,421,948.0	1,448,945.0
210204	Ажилгүйдлийн даатгал	308,600.0	333,743.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,080,400.0	3,337,445.0



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,024,623.0	8,606,639.0
210301	Гэрэл, цахилгаан	3,017,548.0	3,757,409.0
210302	Түлш, халаалт	4,007,075.0	4,811,730.0
210303	Цэвэр, бохир ус	-	37,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,414,985.0	22,279,999.0
210401	Бичиг хэрэг	2,036,495.0	3,091,580.0
210402	Тээвэр, шатахуун	11,454,570.0	12,276,100.0
210403	Шуудан, холбоо, ингернэгийн төлбөр	1,457,600.0	1,925,400.0
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.0	1,474,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,966,320.0	3,512,919.0
2105	Нормативт зардал	23,910,826.0	35,909,240.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,192,226.0	24,809,014.0
210502	Хоол, хүнс	5,476,800.0	7,100,226.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,241,800.0	4,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,794,890.0	16,846,680.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,295,000.0	2,427,800.0
210602	Тавилга	2,000,000.0	8,500,000.0
210604	Урсгал засвар	4,499,890.0	5,918,880.0
2107	Томилолт, зочны зардал	1,094,000.0	723,200.0
210702	Дотоод албан томилолт	1,094,000.0	723,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,102,904.0	18,541,786.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,550,260.0	17,382,560.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	228,250.0	235,090.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,950.0	42,136.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.0	50,000.0
210807	Газрын төлбөр	51,444.0	52,000.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	180,000.0	600,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.0	6,512,320.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.0	6,512,320.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,493,911.0	17,592,224.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,000.0	1,200,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	120,000.0	1,200,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,373,911.0	16,392,224.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,373,911.0	16,392,224.0

					СТ-4А
4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН					
					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний
C01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	108,264,530.63	561,750,881.22



C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	108,264,530.63	561,750,881.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	108,264,530.63	561,750,881.22
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	108,264,530.63	561,750,881.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	108,264,530.63	561,750,881.22
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	60,696,127.46	60,696,127.46
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	168,960,658.09	622,447,008.68

					ТГ
4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН					
					/ төгрөгөөр /
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	264,772,500.0	262,398,589.0	350,511,700.0	312,816,136.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	264,772,500.0	262,398,589.0	350,511,700.0	312,816,136.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРД	264,772,500.0	262,398,589.0	349,311,700.0	311,616,136.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	160,101,600.0	159,813,606.0	210,762,600.0	181,397,048.0
210101	Үндсэн цалин	147,710,200.0	147,710,200.0	142,342,200.0	118,821,197.0
210102	Нэмэгдэл	-	-	40,793,500.0	40,793,500.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	5,020,000.0	3,798,000.0
210104	Урамшуулал	12,391,400.0	12,103,406.0	22,606,900.0	17,984,351.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төл	19,124,300.0	18,963,755.0	26,764,200.0	23,046,324.0
210201	Тэтгэврийн даатгал	12,949,200.0	12,917,707.0	18,199,600.0	16,115,008.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,235,100.0	1,235,100.0	2,141,100.0	1,811,183.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,551,000.0	1,421,948.0	1,712,900.0	1,448,945.0
210204	Ажилгүйдлийн даатгал	308,600.0	308,600.0	428,300.0	333,743.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,080,400.0	3,080,400.0	4,282,300.0	3,337,445.0

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,762,600.0	7,024,623.0	10,784,700.0	8,606,639.0
210301	Гэрэл, цахилгаан	3,609,000.0	3,017,548.0	5,708,500.0	3,757,409.0
210302	Түлш, халаалт	4,053,600.0	4,007,075.0	4,926,200.0	4,811,730.0
210303	Цэвэр, бохир ус	100,000.0	-	150,000.0	37,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,661,400.0	17,414,985.0	22,324,800.0	21,832,899.0
210401	Бичиг хэрэг	2,040,000.0	2,036,495.0	3,100,000.0	3,091,580.0
210402	Тээвэр, шатахуун	11,454,600.0	11,454,570.0	11,799,000.0	11,829,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,666,800.0	1,457,600.0	1,966,800.0	1,925,400.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үйлчилгээ	500,000.0	500,000.0	1,901,000.0	1,474,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.0	1,966,320.0	3,558,000.0	3,512,919.0
2105	Нормативт зардал	22,125,800.0	22,089,826.0	35,008,200.0	34,609,240.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,000,000.0	15,967,226.0	24,808,200.0	24,809,014.0
210502	Хоол, хүнс	4,880,800.0	4,880,800.0	6,200,000.0	5,800,226.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,245,000.0	1,241,800.0	4,000,000.0	4,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,366,400.0	13,294,890.0	16,615,300.0	16,346,680.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,366,400.0	10,295,000.0	2,115,300.0	1,927,800.0
210602	Тавилга	-	-	8,500,000.0	8,500,000.0
210604	Урсгал засвар	3,000,000.0	2,999,890.0	6,000,000.0	5,918,880.0
2107	Томилго, зочны зардал	1,153,000.0	1,094,000.0	1,450,000.0	723,200.0
210702	Дотоод албан томилго	1,153,000.0	1,094,000.0	1,450,000.0	723,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	17,877,400.0	17,102,904.0	19,001,900.0	18,541,786.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	16,992,000.0	16,550,260.0	17,816,900.0	17,382,560.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоо	-	-	180,000.0	180,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.0	228,250.0	250,000.0	235,090.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,400.0	52,950.0	53,000.0	42,136.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.0	40,000.0	50,000.0	50,000.0
210807	Газрын төлбөр	150,000.0	51,444.0	52,000.0	52,000.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээ	380,000.0	180,000.0	600,000.0	600,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.0	5,600,000.0	6,600,000.0	6,512,320.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.0	5,600,000.0	6,600,000.0	6,512,320.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	1,200,000.0	1,200,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	1,200,000.0	1,200,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалт	-	-	1,200,000.0	1,200,000.0